


Манай орны 12 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар  $-21^{\circ}\text{C}$  ( $-5.8^{\circ}\text{F}$ )-аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар  $-15^{\circ}\text{C}$ -аас  $-9^{\circ}\text{C}$  ( $5^{\circ}\text{F}$ -аас  $15.8^{\circ}\text{F}$ ), бусад нутгаар  $-15^{\circ}\text{C}$ -аас  $-24^{\circ}\text{C}$  ( $5^{\circ}\text{F}$ -аас  $-11.2^{\circ}\text{F}$ ) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 12 дугаар сард хур тунадас бага унадаг бөгөөд ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 1 хувьтай тэнцдэг. Олон жилийн дунджаар (1991-2020 оны дунджаар) сардаа томоохон гол, нуурын сав газар болон Ховдын зүүн өмнөд хэсгээр 4 мм-ээс их, бусад нутгаар 0.5-3.8 мм тунадас унадаг.



**Зураг 1.** 1991-2020 оны 12 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн тархалт

2024 оны 12 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс  $2.4^{\circ}\text{C}$ -аар, ОЖД-аас  $1.35^{\circ}\text{C}$ -аар тус тус дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 25 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 23.3% нь дунджаас  $-1.0^{\circ}\text{C}$  -ээс  $-7.0^{\circ}\text{C}$ -аар хүйтэн, 41.1% нь дунджаас  $+1.0^{\circ}\text{C}$  -ээс  $5.3^{\circ}\text{C}$ -аар дулаан, 35.7% нь дунджийн орчим байжээ.


Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 3.2 мм тунадас орсон нь өмнөх жилээс 55.7%-иар бага, ОЖД-аас 8.4%-иар ахиу хур тунадас орсон ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 21 дэх их тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 48.8% нь дунджаас ахиу, 9.3% нь дунджийн орчим, 41.9% нь бага тунадас унасан байна.



**Зураг 2.** 2024 оны 12 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт


Нийт нутгаар болон 4 бүсээр хуваан дунджилсан 12 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) баруун зүгийн нутгаар сарын ихэнх хугацаанд олон жилийн дунджаас (ОЖД) хүйтэн байсан бөгөөд хүйтний эрч гуравдугаар 10 хоногт улам чангарч, ОЖД-аас  $-4^{\circ}\text{C}$ -аас  $-8^{\circ}\text{C}$  хүйтэн байжээ. Төв болон өмнө зүгийн нутгаар сарын эхэнд дулаан, хоёрдугаар 10 хоногт температурын хэлбэлзэл ихтэй, харин гуравдугаар 10 хоногийн ихэнх хугацаанд хүйтрэлт ажиглагдсан. Зүүн зүгийн нутгаар сарын турш тогтвортой дулаан байв.

Хур тунадасны хувьд баруун болон төвийн бүс нутгаар сарын турш харьцангуй ахиу тунадас орсон бол өмнө болон зүүн зүгийн нутгаар бага буюу бараг хур тунадасгүй байлаа.




**Зураг3.** Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

12 дугаар сард  $-30^{\circ}\text{C}$ -аас хүйтэн өдрийн тоо Завханы Отгон, Баянхонгорын Байдраг, Ховдын Цэцэг, Хөвсгөлийн Ренчинхлүмбэ орчмоор 20 өдрөөс их, Увсын Завхан, Малчин, Баян-Өлгийн Дэлүүн, Завханы Нөмрөг, Завханмандал, Цэцэн-Уул, Тосонцэнгэл, Баянтэс, Сэлэнгийн Ерөө орчмоор 15-19 хоног, бусад нутгаар 1-10 хоног ажиглагджээ. Говийн болон зүүн зүгийн нутгаар огт ажиглагдаагүй.



**Зураг 4.**  $-30^{\circ}\text{C}$ -аас хүйтэн өдрийн тооны газарзүйн тархалт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Булганы Тэшиг суманд 3.4°C, үнэмлэхүй бага утга Завханы Отгон суманд -43.4°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй Говь-Алтайн Тоорой суманд 14°C, үнэмлэхүй бага утга Завханы Цэцэн-Уул суманд -45°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Хөвсгөлийн Хатгал суманд 24-ний өдөр 7.1 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 966.8гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 765.3гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Говь-Алтайн Бугат суманд 30м/с хүрчээ.



**Зураг 5.** Тус сард ажиглагдсан экстремаль утгууд